



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

“Улаанбаатар марафон-2017” олон улсын
гүйлтийн тэмцээний үеэр мөрдөх нийтийн тээврийн
үйлчилгээний төлөвлөлтийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэхь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3, 3.1.19 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/147 дугаар “Тэмцээн зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтийн тэмцээний үеэр Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Сөүлийн гудамж, Бээжингийн гудамж, Анкарагийн гудамж, Сүхбаатарын гудамж, Их сургуулийн гудамж, Самбуугийн гудамж, Элчингийн гудамж, Хөх тэнгэрийн гудамж, Партизаны гудамж, Төмөрчний гудамж, Гэндэнгийн гудамж, Олимпийн гудамж, Чоймболын гудамжны автозамын хөдөлгөөн хязгаарлагдахтай холбоотойгоор дээрх гудамж замаар үйлчилдэг нийтийн тээврийн чиглэлүүдийн замналын өөрчлөлтийн нэгдсэн зураглалыг нэгдүгээр, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийг тухайн өдөр түр замналын дагуу явуулахад хяналт тавин ажиллах Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулж, тус өдөр илүү цагаар ажилласан албан хаагчдыг нөхөж амраахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад чиглэлүүдийн өөрчлөлтийн талаар мэдээллийг өгч, үйлчилгээг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, тухайн өдөр ажиллах нийтийн тээврийн хэрэгслийг төлөвлөлтийн дагуу үйлчилгээнд ажилласан эсэхийг нягталж, ажлын гүйцэтгэлийг Удирдлага, мэдээллийн цахим төлбөрийн системээр нэгтгэн гаргахыг Улаанбаатар смарт карт ХХК /Юүн Жун И/-т, чиглэлүүдийн үйлчилгээг өөрчлөгдсөн замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ОТГОНБААТАР



1115108253 ☎ 2117428

